



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 187

Улаанбаатар хот

Үндэсний зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2, Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 3 дугаар сарын 9-ны өдрийн 69 дугаар тогтоолын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий “Үндэсний зөвлөл”-ийг байгуулж бүрэлдэхүүнийг дараах бүтэцтэйгээр баталсугай:

Үндэсний зөвлөлийн дарга: Б.Даажамба- Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн;

Гишүүд: М.Ганхуяг Төрийн өмчийн хорооны Төрийн өмчийн удирдлага, хувьчлалын газрын ахлах мэргэжилтэн;

Б.Арвинбаяр, Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооны Хувийн хэвшил, инновацийн бодлогын хэлтсийн дарга;

М.Энхтөр, Монгол банкны Тамгын газрын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн;

Ч.Нэргүй, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимийн Нэгдсэн бодлого төлөвлөлт зохицуулалтын газрын дарга;

Д.Батжаргал, Компанийн засаглалын хөгжлийн төвийн ТУЗ-ийн дарга;

Ч.Нанжидсамбуу, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны Бизнесийн харилцааны албаны дарга;

Д.Мөнхтүшиг, Монголын хөрөнгийн биржийн дэд захирал.

2. “Үндэсний зөвлөл”-ийн үйл ажиллагааг удирдлагаар ханган хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг “Үндэсний зөвлөл”-ийн дарга /Б.Даажамба/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН